

2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН “ШИНЭ ИРГЭНШИЛ” ДС/МСҮТ-ИЙН БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ**2017 оны 11 дугаар сар 28****Улаанбаатар хот****Нэг. Зорилго**

Шинэ иргэншил дээд сургууль, МСҮТ-ийн эрхэм зорилго, зорилтод нийцүүлэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, багш нарын эрдэм судлалын ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, туршлага солилцоход оршино.

Хоёр. Зохион байгуулалт

Илтгэлийн уралдаанд сургуулийн бүх багш нар хамрагдах ба 2017 оны 2-р сарын эхний 7 хоногт сургуулийн лекцийн танхимд зохион байгуулна. Илтгэлийг урьдчилан гаргасан судалгааны ажлын чиглэлийн дагуу тогтооно. Сэдийг 2018 оны 1-р сарын 3-р 7 хоногт сургалтын албанд мэдэгдэх ба илтгэлийг хэвлэмэл 1 хувь, электрон хэлбэрээр хүлээн авна.

Гурав. Багш нарын бичих ЭШ, судалгаа, арга зүйн илтгэлийн агуулгын чиглэл нь:

Дээд боловсрол болон МСҮТ-ийн сургалт, заах, арга зүйн шинэлэг технологи болон санаачилгыг сургалтад нэвтрүүлэх /өөрийн ажлын жишээн дээр/

Дөрөв. Илтгэлд тавигдах шаардлага**Боловсруулалт болон агуулгын хувьд**

- Шинжлэх ухааны үндэслэлтэй байх
- Шинэлэг санааг дэвшүүлсэн байх
- Онол, практикийн ач холбогдолтой байх
- Судалгааны цар хүрээг оновчтой тодорхойлсон байх
- Санаагаа товч, тодорхой дэвшүүлсэн байх
- Оршил, үндсэн хэсэг, дүгнэлт хэсэг, ашигласан ном, эх сурвалжийн жагсаалт
- Доорх бичлэгийн стандарт шаардлага хангасан байна. Үүнд:
- Microsoft Office Word, Ariel, Size-12, А4 форматаар хуудасны тоо 6-10
- Илтгэлийн сэдэв, зохиогчийн овог нэр

Жич: Илтгэлүүдийг эмхэтгэн хэвлэх учир бичлэгийн шаардлага хангасан байхыг анхаарна уу.

Тав.Хурлын дэг

- Илтгэгч 7 минутад багтаамж илтгэлээ тавих бөгөөд асуулт хариут 10 минут.
- Илтгэлтэй холбоотой материалыг илтгэгч хариуцан бэлтгэнэ.
- Хурал нээлттэй болох бөгөөд шинэ иргэншил дээд сургуулийн захиргаа, эрдмийн зөвлөлөөс томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүж байр эзлүүлнэ.

Зургаа. Дүгнэх журам

Илтгэлийг дүгнэх комисс удирдамжид заасан шаардлагын дагуу шүүн хэлэлцэж шалгаруулна. Тэргүүн байранд шалгарсан илтгэл нь танхимын бус сургалтын багц цагт хамаарах болно.

Эрдмийн зөвлөл, сургуулийн захиргаа